



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/07

Цагаан-Уул сум

Г Иргэний газар өмчлөх эрхийг цуцлах, Г
газрын хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3, 40.2.4, 40.2.5, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Газар өмчилсөн иргэдийн өөрийнх нь хүсэлтийн дагуу кадастрын зургаар талбайн хэмжээнд өөрчлөлт орсон 3 иргэний 2522 м/кв газрын хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын бүртгэлд бүртгэж мэдээллийн санд өөрчлөлтийг тусган захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг Газрын даамал (А.Энхбаатар)-д, эрхийн баталгаанд өөрчлөлт хийлгэхийг Улсын бүртгэгч (Д.Ичинхорлоо)-д тус тус даалгасугай.

3. Сумын Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор сумын Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2025/